



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/239

Улаанбаатар хот

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
салбарын мэргэжилтнийг давтан сургах,
мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрэм
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 14 дүгээр захирамжаар батлагдсан “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.5.9.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан дүрмийг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг салбарын мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, батлагдсан дүрмийг олон нийтэд сурталчлан таниулж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий
газрын даргын 2024 оны А/239 дугаар тушаалын хавсралт

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН
МЭРГЭЖИЛТНИЙГ ДАВТАН СУРГАХ, МЭРГЭШЛИЙН
ЗЭРЭГ ОЛГОХ, СУНГАХ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Орчин үеийн мэдлэг, ур чадвартай, онол, практикийн дадлага эзэмшсэн боловсон хүчнийг бэлтгэн, сургаж хөгжүүлэх үүднээс Монгол Улсын газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах үйл ажиллагааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтэн (цаашид “салбарын мэргэжилтэн” гэх)-ийг давтан сургах сургалт болон шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.3. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтэн нь мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэгтэй байна. Эдгээрийг мэргэшлийн зэрэг (цаашид “мэргэшлийн зэрэг” гэх) гэж ойлгоно.

1.4. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, цуцлах, хяналт тавих үйл ажиллагааг газрын болон геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “сургалт зохион байгуулагч” гэх) хэрэгжүүлнэ.

1.5. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг хэлэлцэн дүгнэлт гаргах үүргийг “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл” (цаашид “Зөвлөл” гэх) хариуцна.

1.6. Энэ дүрмийн 1.4-д заасан сургалт зохион байгуулах чиг үүргийг холбогдох шийдвэрийг үндэслэн салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

1.7. Салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалтыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн үндсэн дээр салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллагаар (цаашид “сургалт эрхлэгч байгууллага” гэх) гэрээгээр гүйцэтгүүлж болно.

1.8. Салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох сургалтад хамрагдсан мэргэжилтнээс батлагдсан материалаар шалгалт авах бүрэлдэхүүн (цаашид “шалгалтын комисс” гэх)-ийг агентлагийн даргын шийдвэрээр томилж, чөлөөлнө.

1.9. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтэн гэдэгт газар зохион байгуулалт (газрын удирдлага, менежмент, төлөвлөлт), газрын кадастр (газрын үнэлгээ, газар зүйн мэдээллийн систем), геодези (геодезийн инженер, инженер геодези, сансрын геодези-астрономи, геодезийн мэдээлэл зүй,

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЭХ ХҮБ
ХАМГААГАХ БАТ 139
ДУШАЛ
А/239

зайнаас тандан судлал, фотограмметр, аэрофотогеодези, агаарын зураглал), зураг зүйн мэргэжилтэй бакалаврын зэрэгтэй салбарын мэргэжилтэн тус тус хамаарна.

Хоёр. Мэргэшлийн зэрэг олгох, түүнд тавигдах шаардлага

2.1.Газар зохион байгуулалт, газрын кадастрын мэргэжилтэй мэргэжилтэнд дараах үйл ажиллагааны хүрээнд мэргэшлийн зэрэг олгоно. Үүнд:

2.1.1.газар зохион байгуулалт (газрын удирдлага, менежмент, төлөвлөлт);

2.1.2.кадастр (газрын үнэлгээ);

2.2.Геодези, зураг зүйн мэргэжилтэй мэргэжилтэнд дараах үйл ажиллагааны хүрээнд мэргэшлийн зэрэг олгоно. Үүнд:

2.2.1.геодезийн хэмжилт, зураглал (сансрын геодези, астрономи; инженер геодези; геодезийн мэдээлэл зүй; хэрэглээний геодези; агаарын зураглал, аэрофотогеодези);

2.2.2.зураг зүй (зураг зүй, гео-информатик; газар зүйч-зураг зүйч);

2.3."Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шаардлага"-ыг энэ дүрмийн нэгдүгээр хавсралтад зааснаар тогтооно.

Гурав.Сургалт зохион байгуулагч байгууллагын чиг үүрэг

3.1.Сургалт зохион байгуулагч байгууллага нь салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах үйл ажиллагаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1.мэргэжил дээшлүүлэх сургалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.2.Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах;


3.1.3.заавал суралцах багц цагийн сургалтын агуулга, тухайн жилийн сургалтын нэгдсэн төлөвлөгөө (заавал болон сонгон суралцах багц цагийн), шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний төслийг боловсруулж Зөвлөлөөр хэлэлцүүлж, батлах;

3.1.4.сургалтын хөтөлбөрийг Зөвлөлөөр хэлэлцүүлж, батлах;

3.1.5.сургалтын хөтөлбөр, агуулгатай уялдуулан сургалтын төлбөрийн жишиг хэмжээг тогтоох саналыг Зөвлөлд танилцуулж, шийдвэрлэх;

3.1.6.мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтын сэдэв, асуулт, бодлого, загварчлал, даалгаврыг боловсруулах тестийн нэгдсэн санг тогтмол шинэчлэх, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.7.тестийн нэгдсэн сан, реферат бичих заавар, рефератын сэдэв, зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн орчин үеийн дэвшилтэт технологийн болон тусгайлсан рефератын сэдэв болон шалгалтын комиссын бүрэлдэхүүний талаар санал боловсруулж Зөвлөлөөр хэлэлцүүлж, батлах;



3.1.8.Их, дээд сургуулийг салбарын шинэ мэргэжлийн чиглэлээр төгссөн мэргэжилтний зэрэг горилох хүрээг нэмэгдүүлэх асуудлаар санал боловсруулан Зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлэх;

3.1.9.сургалт эрхлэгч байгууллагын сургалтын явцтай танилцах, үйл ажиллагаанд хяналт тавих, сургалтын тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.10.мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтад орох хүсэлт гаргасан мэргэжилтний материалыг хүлээн авч, шалгалтыг зохион байгуулах, шалгалтын комиссоос гаргасан шалгалтын дүнг Зөвлөлөөр хэлэлцүүлж, батлах;

3.1.11.мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан болон мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтний талаарх нэгдсэн мэдээллийн санг хөтөлж, мэдээлэл, лавлагаагаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үйлчлэх;

3.1.12.мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн нь мэргэшил дээшлүүлэх сургалтаар болон бие даасан хэлбэрээр багц цаг бүрдүүлсэн тухай мэдээлэл, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор хүлээн авч, нэгдсэн бүртгэлийг хөтөлж, Зөвлөлд танилцуулах;

3.1.13.бие даасан багц цаг хангасан эсэхэд дүгнэлт гаргах үүрэг бүхий хяналтын баг томилон ажиллуулах;

3.1.14.хяналтын багийн үйл ажиллагаанд хяналт тавих, гаргасан дүгнэлттэй танилцах, дүгнэлтийг үндэслэн бие даасан багц цаг хангасныг баталгаажуулж, мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтад орох эрх нээх;

3.1.15.холбогдох тайлан, мэдээг боловсруулж Зөвлөлд хүргүүлэх, мэргэжилтний ирүүлсэн багц цаг хангасан тайлан, нотлох баримт болон сургалт, шалгалтын материалаар архивын нэгж үүсгэн хадгалах;

3.1.16.мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж Зөвлөлд хүргүүлэх;

3.1.17.холбогдох дүгнэлт, шийдвэрийг үндэслэн салбарын мэргэжилтний мэргэшлийн зэргийг хүчингүй болгох;

3.1.18.салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалт зохион байгуулах журмыг батлах;

3.1.19.салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалт эрхлэгч байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;

3.1.20.сургалт болон сонгон шалгаруулалттай холбогдон гарсан гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;

3.1.21.мэргэшлийн зэргийн гэрчилгээ, тэмдгийн загвар батлах, тэдгээрийг олгох, хүчингүй болгох;

3.1.22.энэ дүрмийн хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу мэргэшлийн зэргийн гэрчилгээ, хувийн тэмдэг олгох;

3.1.23.мэргэшлийн зэргийн гэрчилгээ, тэмдгийг ёслол хүндэтгэлтэй гардуулах.

Дөрөв. Сургалт эрхлэгч байгууллагад тавигдах шаардлага, хэрэгжүүлэх чиг үүрэг

4.1.Салбарын мэргэжилтнийг давтан сургах сургалтыг зохион байгуулагч нь дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1.салбарын мэргэжилтнийг давтан сургах сургалтыг зохион байгуулах туршлагатай байх;

4.1.2.стандартын шаардлага хангасан сургалтын анги, танхим, сургалтын материал, техник, тоног төхөөрөмжтэй байх;

4.1.3.салбарын мэргэжилтнийг давтан сургах эрэлт хэрэгцээ, чиг хандлагад нийцсэн загвар сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, аргачлалыг боловсруулсан байх;

4.1.4.сургалтад хичээл заах багш нар нь мэргэшсэн болон зөвлөх инженер, магистр түүнээс дээш зэрэгтэй, багшлах туршлагатай байна. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн программ хангамжийн сургалтад хичээл заах агентлагийн албан хаагчдад энэ заалт хамаарахгүй.

4.2.Сургалт эрхлэгч байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.1.давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалт зохион байгуулах ажлын гэрээг зохих журмын дагуу байгуулж ажиллах;

4.2.2.сургалтын хөтөлбөр, нэгдсэн төлөвлөгөө болон түүнийг үндэслэн тооцсон сургалтын багц цагийн үнэлгээг боловсруулан Зөвлөлд уламжлан хэлэлцүүлэх;

4.2.3.зохион байгуулсан багц цагийн сургалтын агуулгаар 50-аас доошгүй шалгалтын тест боловсруулж Зөвлөлд хүргүүлэх;

4.2.4.сургалтад оролцож, шаардлагатай багц цаг хангасан сургалтын тайлан болон шалгалтын комиссын дүгнэлтийг сургалт дууссанаас хойш ажлын 10 өдөрт багтаан Зөвлөлд хүргүүлэх;

4.2.5.гэрээний үндсэн дээр зохион байгуулах багц цагийн сургалтад энэ дүрмийн нэгдүгээр хавсралтад заасан шаардлагыг хангасан мэргэжилтэнг бүртгэх, материалын бүрдэл, эх сурвалжид хяналт тавих, бүрэн бус материал хүлээн авахгүй байх;

4.2.6.сургалтыг зориулалтын анги, танхимд зохион байгуулах, материал, тоног төхөөрөмжөөр хангах;

4.2.7.Сургалт зохион байгуулагч байгууллагаас болон Зөвлөлөөс ирүүлсэн санал, зөвлөмж, шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах;

4.2.8.багц цагийн сургалтын талаар судалгаа хийх, дотоод хяналт тавих, санал асуулга авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллах;

4.2.9.сургалтын хөтөлбөр, нэгдсэн төлөвлөгөөний дагуу салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалтыг чанартай зохион байгуулах;

4.2.10.сургалтын үйл ажиллагааны талаар хагас, бүтэн жил тутамд сургалт зохион байгуулагч байгууллагад тайлагнах;

4.2.11.сургалтын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй мэдээлэх, сургалт зохион байгуулагч байгууллагаас зөвшөөрөл олгосон нэгдсэн мэдээллийн санг ашиглах, лавлагаа, мэдээллээр үйлчлэх;

4.2.12.энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомжийг чанд баримтлан ашиг сонирхлын зөрчилгүй, үнэнч шударга ажиллах;

4.2.13.сургалтад хамрагдсан болон мэргэшлийн зэрэг авсан мэргэжилтнүүдийн анкет, материал, мэдээлэл бусад холбогдох баримт бичгийг архивын нэгж үүсгэн, дараа жилийн эхний улиралд багтаан сургалт зохион байгуулагч байгууллагад шилжүүлнэ.

4.2.14.сургалт эхлэхээс 7 хоногийн өмнө багш тус бүрээс заах сэдвийн агуулгын хүрээнд 5 тест авч, шалгалтын сан бүрдүүлэх;

4.2.15.сургалт эхлэхэд мэргэшлийн зэрэг горилох, сунгах мэргэжилтний бие даан суралцах багц цаг хангасан тайланг нотлох баримтын хамт хүлээн авч хяналтын багт хүргүүлэх;

4.2.16.сургалтын төгсгөлд мэргэшлийн зэргийн ангилал, түвшин тус бүрд заагдсан хичээлүүдийн агуулгыг бүрэн багтаасан болон мэргэжилтний сургалтад хамрагдсан ирцэд харгалзах хичээлийн сэдвийн хүрээнд шалгалтын сангаас санамсаргүй байдлаар сонгогдсон 20 тестээр шалгалт авах;

4.2.17.сургалтад хичээл заах багшийн ажлын гүйцэтгэл болон заах сэдвийн агуулга, тестийн материал ирүүлэхэд хяналт тавьж ажиллах, шаардлагатай тохиолдолд хичээл заах эрхийг түдгэлзүүлэх саналыг ажлын албанд хүргүүлэх.

4.3.Сургалт зохион байгуулагч байгууллага энэ дүрмийн 1.7-т заасны дагуу сургалт эрхлэгч байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж болно. Энэ тохиолдолд энэ дүрмийн 4.2-д заасан чиг үүргийг мөн адил хэрэгжүүлнэ.

4.4.Сургалт нь тухайн салбарын мэргэжилтний мэргэшлийн зэрэгтэй уялдаж, салбарын эрэлт, хэрэгцээнд тулгуурласан, агуулгын хувьд суралцагсдад онолын болон дадлагын мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн байна.

4.5.Сургалтын хөтөлбөрт сургалтын нэр, төрөл, мэргэшүүлэх чиглэл, зорилго, агуулга, арга зүй, цагийн багтаамж, олгогдох багц цаг, санхүүжилт, төлбөрийн хэмжээ, сургагч багшид тавигдах шаардлага, сургалтад хамрагдах мэргэжилтний үйл ажиллагааны хүрээ, тоо, сургалт явагдах газар, хугацаа, сургалтын хэрэглэгдэхүүн (гарын авлага, тараах материал), шалгалтын хэлбэрийг тусгасан байна.

4.6.Сургалтын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулах ба түүнд сургалтын төрөл, чиглэл, сэдэв, сургалт эрхлэх хэлбэр, хугацааг нарийвчлан тусгана. Сургалт нь заавал болон сонгон сурах гэсэн 2 төрөлтэй байна.

4.7.Энэ дүрмийн 4.2.16 заалтад заасан шалгалтын тестийн 70-аас доошгүй хувийг зөв хариулсан тохиолдолд багц цаг хангасанд тооцож, мэргэшлийн зэрэг горилох сунгах шалгалтад орох эрх нээгдэнэ.

4.8.Мэргэжилтэн нь давтан сургалтын шалгалтад 70 хувиас бага үнэлгээ авсан бол 10 хоногийн дараа дахин шалгалтыг үнэ төлбөргүй өгч болох ба тэнцээгүй

ЭХ ХҮБ
А/239

тохиолдолд дараагийн сургалтад төлбөр төлж суралцана.

Тав. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагаа

5.1.Мэргэжилтний мэргэшсэн зэргийг 3 жил, зөвлөх зэргийг 5 жилийн хугацаагаар тус тус олгоно. Мэргэшсэн, зөвлөх зэргийг тус бүр 2 удаа сунгаснаар хугацаагүй эрхтэйд тооцно.

5.2.Доорх шаардлагыг хангасан нь холбогдох мэргэжлийн зөвлөл, шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн бол Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн салбарын мэргэжилтэнд агентлагийн даргын шийдвэрээр энэ дүрмийн 5.1-т заасан хугацаанаас өмнө мэргэшлийн зэргийг олгож болно. Үүнд:

5.2.1.газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, газрын кадастрын үйлдвэрлэлд технологийн шинэ дэвшил гаргасан;

5.2.2.улс орны болон салбарын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой төсөл, хөтөлбөр, эрдэм шинжилгээний бүтээл боловсруулж, түүнийг гардан хэрэгжүүлж бодитой үр дүн гаргасан;

5.2.3.энэ дүрмийн нэгдүгээр хавсралт “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шаардлага”-д заасан норм, нормативын баримт бичгийг 3-аас дээш удаа боловсруулж, батлуулсан;

5.2.4.Салбарын мэргэжилтэн нь тухайн мэргэжлийн хүрээнд докторын зэрэг хамгаалсан.

5.3.Салбарын төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн болон удирдах албан тушаалтан нь төрийн захиргааны дэс болон түүнээс дээш албан тушаалын ангилал зэрэглэлд 5-аас доошгүй жил идэвх санаачилгатай ажилласан бол Зөвлөлийн дүгнэлтээр сургалтын багц цагийг хангасанд тооцно.

5.4.Сургалтын жилийн төлөвлөгөөний дагуу мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан бол мэргэшлийн зэрэг горилох, сунгах шалгалтад орох хүсэлтээ сургалт зохион байгуулагчид шалгалт зохион байгуулахаас 30 хоногийн өмнө хүсэлт гаргасан байна.

5.5.Зэрэг горилох, сунгах салбарын мэргэжилтэн нь дараах баримт бичгийг бүрдүүлж, сургалт зохион байгуулагчид хүргүүлнэ. Үүнд:

5.5.1.мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтад орохыг хүссэн өргөдөл;

5.5.2.иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа;

5.5.3.анкет (энэхүү дүрмийн тавдугаар хавсралт);

5.5.4.цээж зураг (3х4 хэмжээтэй 2 хувь);

5.5.5.мэргэжлийн дипломын хуулбар (хэрэв гадаадад боловсрол эзэмшсэн бол баталгаат орчуулгыг хавсаргах);

5.5.6.бүтээлийн жагсаалт;

5.5.7.багц цагийн сургалтад хамрагдсан сургалтын гэрчилгээний хуулбар;

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БРЕНДИНГ ГАЗАР
ЭХ ХҮБЬ
Хувиар
А/239

5.5.8.танхимын сургалтаар заавал болон сонгон суралцах багц цаг тооцсон сургалтын батламж, хуулбар.

5.6.Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа дууссан, зэрэг сунгах шалгалтад ороогүй эсвэл шалгалтад 2 удаа тэнцээгүй бол мэргэшлийн зэрэг хүчингүй болсонд тооцно.

5.7.Салбарын мэргэжилтэн нь мэргэжлийн алдаа дутагдал гаргасныг эрх бүхий байгууллагаас тогтоосон, мэргэжлийн ёс зүйн дүрэм, стандартыг зөрчсөн бол Зөвлөлийн саналыг үндэслэн агентлагийн даргын шийдвэрээр мэргэшлийн зэргийг хүчингүй болгоно.

5.8.Мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгохтой холбогдон гарсан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлнэ.

Зургаа. Мэргэшлийн зэргийн гэрчилгээ, тэмдэг

6.1.Мэргэшлийн зэрэгтэй салбарын мэргэжилтэнд гэрчилгээ, хувийн тэмдэг олгоно.

6.2.Салбарын мэргэжилтний “Мэргэшсэн инженер”, “Зөвлөх инженер” мэргэшлийн зэргийн гэрчилгээ А4 форматтай, ижил загвартай байна.

6.3.Гэрчилгээний хуудас, бичвэр нь мэргэшлийн зэрэг тус бүрээр ялгаатай байна. “Мэргэшсэн инженер” мэргэшлийн зэргийн гэрчилгээ ногоон, “Зөвлөх инженер” мэргэшлийн зэргийн гэрчилгээ бор өнгөтэй байна.

6.4.Гэрчилгээний дээд тал гол хэсэгт Засгийн газрын соёмбо бүхий лого Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар гэсэн бичвэрийн хэмжээ 8 байна. “Гэрчилгээ” гэсэн бичвэрийн доод талд “МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР” эсхүл “ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР” гэж бичиж, мэргэжилтний 3*4 хэмжээтэй цээж зураг, овог нэр, дугаар байна. Дугаарыг дараах дарааллаар бичнэ:

Тухайлбал: 2024-001 гэж бичсэнийг:

2024 - Мэргэшлийн зэрэг олгосон он

001 - Монгол Улсын нийт “Зөвлөх инженер” зэрэг олгосон 001 дэх инженер гэж ойлгоно.

6.5.Гэрчилгээний хуудаст мэргэжилтний эцэг/эхийн нэр, өөрийн нэр, мэргэшлийн зэрэг олгох тухай шийдвэрийн нэр, огноо, мэргэшлийн зэргийн шатлал, чиглэл, хүчинтэй хугацааг бичиж, дараах албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулан тамга дарсан байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын овог нэр, гарын үсэг, тамга (эцэг/эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр, гарын үсэг, тамга)

6.6.Гэрчилгээний доод хэсэгт олгосон огноог бичнэ.

6.7.Мэргэшлийн зэргийн гэрчилгээ нь монгол, англи хувилбартай байна.

6.8.Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэнд гэрчилгээний хамт хувийн тэмдэг олгоно. Хувийн тэмдэгт эзэмшигчийн нэр, бүртгэлийн дугаар, зэргийн хүчинтэй байх

ХАМГААГАХ
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЗХ ХУУЛЬ
Хууль
#1239

хугацааг заах бөгөөд гэрчилгээ, хувийн тэмдгийн загварыг энэ дүрмийн хоёрдугаар хавсралтаар батална.

6.9.Мэргэшлийн зэргийн гэрчилгээ, хувийн тэмдгийг үрэгдүүлсэн нөхцөлд холбогдох нотлох баримт, мэргэшлийн зэрэг олгосон шийдвэрийг тус тус үндэслэн агентлагийн даргын шийдвэрээр төлбөртэйгөөр нөхөн олгоно.

Долоо. Мэргэжил дээшлүүлэх давтан сургах сургалтын багц цаг тооцох

7.1.Салбарын мэргэжилтнийг давтан сургах сургалтыг танхимын болон бие даасан хэлбэрээр зохион байгуулна.

7.2.Мэргэшлийн зэргийн сургалтыг заавал болон сонгон сурах багц цагийн сургалтын хэлбэрээр хэрэгжүүлнэ. Сургалтын багтаамжийг багц цагаар хэмжинэ.

7.3.Мэргэшлийн зэрэг горилох, сунгах салбарын мэргэжилтэн жил бүр 5-аас доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх бөгөөд сургалтын хэлбэрээр болон бие даасан хэлбэрээр сургалтын багц цагийг хангана.

7.4.Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн сургалтад хамрагдсан бол багц цагийг хангасан гэж тооцно.

7.5.Сургалт хэлбэрээр багц цагийг тооцохдоо 8 цагийн хичээлийг мэргэжил дээшлүүлэх сургалтын 1 багц цаг, дадлага сургалтын 16-аас доошгүй цагийн хичээлийг сургалтын 1 багц цаг гэж тус тус тооцно. Нэг цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут байна.

7.6.Мэргэшлийн зэрэг горилох, сунгах мэргэжилтэн нь бүтээлийн тайлангаа дүрмийн гуравдугаар хавсралтад заасны дагуу гаргаж, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал болон тухайн мэргэжлийн чиглэлээр зөвлөх зэрэгтэй инженерээр баталгаажуулан, холбогдох баримтын хамт Зөвлөлд хүргүүлнэ.

7.7.Мэргэшлийн зэрэг горилох, сунгах мэргэжилтэн нь мэргэжил дээшлүүлсэн тайлангаа бодит цагийн хэмжээ болон багц цагаар тооцож дүрмийн дөрөвдүгээр хавсралтад заасны дагуу гаргаж, сургалт зохион байгуулсан болон холбогдох байгууллагаар баталгаажуулан баримтын хамт Зөвлөлд хүргүүлнэ.

7.8.Бие даасан хэлбэрээр багц цагийг тооцохдоо дараах журмыг баримтална.

7.8.1.салбарын чиглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт эрх бүхий этгээдийн шийдвэрээр томилогдон ажиллаж хууль батлагдсан бол 3 багц цаг;

7.8.2.хуулийг дагалдан гарах дүрэм, журмын төслийг боловсруулж, батлуулсан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн бол 3 багц цаг;

7.8.3.салбарын чиглэлээр норм, дүрэм, стандартын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан ба тухайн нормативын баримт бичиг нь батлагдсан бол 4 багц цаг;

7.8.4.мэргэжлийн ном, нэг сэдэвт бүтээл зохиож нийтлүүлсэн бол 4 багц цаг;

7.8.5.мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсэн бол 1 багц цаг, гадаадын мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсэн бол 1 багц цаг;

7.8.6.тухайн жилд магистрын зэрэг хамгаалсан, хамгаалсан сэдвийн чиглэл нь мэргэшлийн хүрээнд нийцсэн бол 4 багц цаг;

7.8.7.тухайн жилд доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан, хамгаалсан сэдвийн чиглэл нь мэргэшлийн хүрээнд нийцсэн бол 8 багц цаг;

7.8.8.салбарын чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулж батлуулсан, түүнд оролцсон бол 1 багц цаг;

7.8.9.сургалтын хөтөлбөр боловсруулсан, мэргэжил дээшлүүлэх сургалтад багшаар оролцон хичээл заасан бол хичээлийн 4 цаг тутамд 1 багц цаг.

7.9.Мэргэшсэн зэрэг горилох мэргэжилтэн нь сургалтын хэлбэрээр 11 багц цагийг хангасан байна. Үүнээс сургалтын хэлбэрээр заавал суралцах 5 багц цаг, сонгон суралцах 5 багц цаг, бие даасан хэлбэрээр 1 багц цаг тус тус бүрдүүлнэ.

7.10.Мэргэшсэн зэрэг сунгах мэргэжилтэн нь зэргийн хүчинтэй хугацаандаа 15 багц цагийг хангасан байна. Үүнээс сургалтын хэлбэрээр 10 багц цагийг (заавал суралцах 5 багц, сонгон суралцах 5 багц), бие даасан хэлбэрээр 5 багц цагийг бүрдүүлнэ.

7.11.Зөвлөх зэрэг горилох мэргэжилтэн нь энэ дүрмийн 5.1 дахь заалтын дагуу мэргэшсэн зэрэг нь хугацаагүй эрхтэй болсноос хойш 3 жилийн хугацаанд заавал суралцах сургалтын 3 багц цагийг хангана. Хугацаа нь 3-аас дээш жил болсон тохиолдолд 10 багц цагийг хангасан байна. Үүнээс сургалтын хэлбэрээр заавал суралцах 5 багц цаг, бие даасан хэлбэрээр 5 багц цагийг бүрдүүлнэ.

7.12.Зөвлөх зэрэг сунгах мэргэжилтэн нь зэргийн хүчинтэй хугацаанд 15 багц цагийг хангасан байна. Үүнээс сургалтын хэлбэрээр заавал суралцах 3 багц цаг, сонгон суралцах 2 багц цаг, бие даасан хэлбэрээр 10 багц цагийг бүрдүүлнэ.

7.13.Хяналтын баг мэргэжилтний ирүүлсэн тайлан, нотлох баримт, материалд дүн шинжилгээ хийж, энэ дүрмийн 7.8-д заасны дагуу бие даасан хэлбэрээр багц цаг хангасан эсэхэд дүгнэлт гаргана.

Найм. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтын комиссын чиг үүрэг

8.1.Шалгалтын комисс нь салбарын мэргэжилтний мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадварыг шалгалтаар, ажлын туршлагыг бүтээлийн болон багц цаг хангасан тайлангийн дагуу магадлан шалгаж тодорхойлно.

8.2.Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтыг агентлагийн даргын баталсан журмын дагуу зохион байгуулна.

8.3.Сургалт зохион байгуулагч байгууллага тухай бүр Зөвлөлийн саналыг үндэслэн шалгалтын комиссыг томилж ажиллуулна.

8.4.Мэргэшсэн инженер, зөвлөх инженерийн зэрэг олгох шалгалт нь хоёр үе шаттай байна.

8.4.1.мэргэшсэн зэрэг горилох шалгалт нь:

Нэгдүгээр шатанд: зэрэг горилох чиглэлээр мэргэжлийн мэдлэгийг шалгах
тестийн шалгалт;

Хоёрдугаар шатанд:

а) мэргэжлийн хүрээнд тодорхой сэдэв, даалгавраар тогтоосон хугацаанд техникийн шийдэл гаргах, тооцоолол, хэмжилт боловсруулалт хийх;

б) газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн хүрээнд хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, журам, заавар, техник технологийн талаар зураг төсөлд тусгасан шийдлийг тайлбарлаж бичих буюу мэргэжлийн ур чадварын шалгалт тус тус өгнө.

8.4.2.зөвлөх зэрэг горилох шалгалт нь:

Нэгдүгээр шатанд: зэрэг горилох чиглэлээр мэргэжилтний мэргэжлийн мэдлэгийг шалгах тестийн шалгалт;

Хоёрдугаар шатанд: сэдвийн хамгаалалт буюу мэргэжлийн ур чадварыг шалгах шалгалтыг тус тус өгнө. Сэдвийн хамгаалалт нь реферат танилцуулгыг сонсож, хэлэлцэх, ярилцлага хэлбэртэй байна.

8.4.3.мэргэшсэн, зөвлөх зэрэг сунгах шалгалт нь:

Нэгдүгээр шатанд: зэрэг сунгах чиглэлээр мэргэжлийн мэдлэгийг шалгах
тестийн шалгалт:

Хоёрдугаар шатанд: зэргийн хүчинтэй хугацаанд гүйцэтгэсэн шийдэл гаргасан бүтээл, тодорхой сэдвээр судалгаа хийсэн, харьцуулсан үр дүн, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан хамгаалалт (тухайн салбарын мэргэжилтний мэргэшлийн хүрээнд гүйцэтгэсэн ажил, бүтээл) хэлбэрээр авна. Тайлан хамгаалалт нь ярилцлагын хэлбэртэй байна.

8.5.Шалгалтын сэдэв, даалгавар, асуулт, бодлого, өгөгдлийг тестийн нэгдсэн сангаас сонгох бөгөөд эдгээр нь шалгалт авах өдөр, цаг хүртэл нууцлагдана.

8.6.Нэгдүгээр шатны шалгалтад тэнцсэн мэргэшсэн болон зөвлөх зэрэг горилогч нь дараагийн шатны шалгалт, тайлан, сэдвийн хамгаалалтад орно.

8.7.Зөвлөх зэрэг горилох, сунгах мэргэшсэн болон зөвлөх зэрэг горилогч нь сэдвийн хамгаалалтын баримт бичгийг шалгалтын товлосон хугацаанаас 10 хоногийн өмнө шалгалтын комисст ирүүлнэ.

8.8.Шалгалтын комиссын гишүүд зөвлөх зэрэг горилох, сунгах салбарын мэргэжилтний илтгэлийг түүний онол, техник технологийн шийдэл, түвшин, мэдээлэл, норм, стандартын тусгалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж, нэвтрүүлсэн байдал, шинэлэг санаа, ач холбогдол, асуултад хариулсан байдал зэрэг үзүүлэлтээр дүгнэнэ.

8.9.Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалт, сэдвийн хамгаалалтаар авсан дүнгийн нийлбэрийг шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нэгтгэн дүгнэж, эцсийн дүнг гаргах ба комиссын дарга энэ дүнг комиссын гишүүдээр хэлэлцүүлэн гишүүн бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

8.10.Комиссын гишүүдэд нөлөөлөхийг оролдсон мэргэшлийн зэрэг горилогч, сунгагчийг, үндэслэлгүй бусдаас хэт зөрүүтэй үнэлсэн гишүүнийг комисс хэлэлцэж, түүний үнэлгээг комиссын нэгдсэн дүнд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

8.11.Шалгалтын комисс нь мэргэшлийн зэрэг горилох, сунгах салбарын мэргэжилтний шалгалт, сэдвийн хамгаалалтын дүнг үндэслэн зэрэг олгох, сунгах шийдвэр төсөл, дүгнэлтээ агентлагт ирүүлж, шийдвэрлүүлнэ.

8.12.Мэргэшлийн зэрэг горилох, сунгах шалгалтад орох иргэн нь шалгалтын комиссын гишүүний хамаарал бүхий этгээд байгаа тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзана.

Ес. Мэргэшлийн зэрэгтэй салбарын мэргэжилтний эрх, үүрэг

9.1.Мэргэшлийн зэрэгтэй салбарын мэргэжилтэнд мэргэжлээрээ ажиллахад Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгож болно.

9.2.Мэргэшлийн зэргийн сарын нэмэгдлийн дээд хэмжээг мэргэжилтний сарын цалингийн хэмжээнээс дор дурдсан хувиар тогтоож, байгууллагын даргын шийдвэрээр олгоно. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээг үндсэн цалингаас мэргэшсэн инженерт 10 хувь, зөвлөх инженерт 20 хувиар тус тус тооцож олгоно.

9.3.Энэ дүрмийн 9.1-д заасан нэмэгдлийг эрдмийн зэрэг цолны нэмэгдэлтэй давхардуулан авч болно. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл нь төрийн албан хаагчид хамаарахгүй.

9.4.Мэргэшсэн зэрэгтэй салбарын мэргэжилтний эрх, үүрэг:

9.4.1.ажил, үйлчилгээгээ холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, стандартын дагуу хариуцлагатай, чанартай хийж гүйцэтгэх;

9.4.2.мэргэжлийн хүрээнд удирдан зохион байгуулсан ажлын чанар, үр дүнг бүрэн хариуцах;

9.4.3.өөрийн буруутай үйлдэл, эс үйлдлээс учирсан эрсдэл, хохирлыг хариуцах;

9.4.4.мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулж болно;

9.4.5.мэргэжлийн ёс зүйтэй ажиллах;

9.4.6.байгууллагын зүгээс албан үүрэгтэй нь холбогдуулан тавьсан шаардлага нийтийн ашиг сонирхолтой зөрчилдвөл нийтийн ашиг сонирхлыг илүүд үзэх;

9.4.7.ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг байгууллагын удирдлагад мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлэх;

9.4.8.гүйцэтгэсэн ажил, бүтээлийн болон сургалтын багц цаг хангасан тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Зөвлөлд хүргүүлэх;

9.4.9.эрх бүхий албан тушаалтны шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор мэргэшлийн зэргийн гэрчилгээ, хувийн тэмдэг олгохыг сургалт зохион байгуулагч байгууллагаас шаардах;

9.4.10.хувийн хэргээ баяжуулах, сургалтын багц цаг хангасан талаарх өөрийн мэдээлэл, бүртгэлтэй танилцах, лавлагаа авах, буруу мэдээллийг залруулах;

9.4.11.тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагын дагуу салбарын мэргэжилтний хувьд оролцох.

9.5.Зөвлөх зэрэгтэй салбарын мэргэжилтний эрх, үүрэг:

9.5.1.энэ дүрмийн 9.4-д заасан эрх, үүргийг мөн адил хэрэгжүүлж ажиллах;

9.5.2.эрх бүхий байгууллагад бүртгүүлснээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

9.5.3.геодезийн хэмжилт зураглалын зөвлөх инженер, мэргэшсэн инженер горилж байгаа салбарын мэргэжилтэн нь онцгой төвөгшилтэй хэмжилт, зураглалд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн дүгнэлт гаргах.

9.6.Салбарын мэргэжилтэн нь бие даасан хэлбэрээр багц цаг хангасан тодорхойлолтыг өөрөө гаргаж, зохих нотлох баримтын хамт Зөвлөлд жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлж байна. Мэргэжилтэн нь өөрийн мэргэжлийн чиглэлээр бие даасан хэлбэрээр багц цаг хангахад ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Тухайн жилд ноогдох багц цаг хангаагүй бол дараа жил нөхөн гүйцээж болно.

Арав.Хяналт шинжилгээ, үнэлгээ

10.1.Сургалт зохион байгуулагч байгууллагаас мэргэшлийн зэрэгтэй салбарын мэргэжилтний тайлан, сургалт эрхлэгч байгууллагын тайланг хүлээн авч, Зөвлөлийн гишүүдийг оролцуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

10.2.Сургалт зохион байгуулагч байгууллагаас Зөвлөлийн болон сургалт эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд жилд 2 удаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

10.3.Сургалт эрхлэгч байгууллага нь хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж ажиллана.

10.4.Сургалт эрхлэгч байгууллага нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.

__о О о__

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын
мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг
олгох, сунгах дүрмийн нэгдүгээр хавсралт



**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭНД
МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

№	Мэргэжлийн хүрээ	Мэргэшлийн зэрэг	Мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шаардлага	
1	Газар зохион байгуулалт (газрын удирдлага, менежмент, төлөвлөлт)	Мэргэшсэн	Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх
			Ажилласан жил	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх
			Бусад шаардлага	- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийн 7.11, 7.12 дугаар заалтын шаардлагыг хангасан байх; - Мэргэшлийн зэрэг сунгах мэргэжилтэн нь мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулахад оролцсон, хянан тохиолдуулсан, шүүмж хийсэн, санал өгч тусгуулсан байх; - Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах программ хангамжийг бүрэн эзэмшсэн байх; - Үйл ажиллагааны хүрээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн 5-аас доошгүй бүтээлтэй байх.
		Зөвлөх	Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж, дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх
			Ажилласан жил	Мэргэжлээрээ 11-ээс доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх
			Бусад шаардлага	- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийн 7.13, 7.14 дүгээр заалтын шаардлагыг хангасан байх; - Мэргэжлийн чиглэлээр 2-оос доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулахад оролцсон, хянан тохиолдуулсан, шүүмж хийсэн, санал өгч тусгуулсан байх; - Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах программ хангамжийг бүрэн эзэмшсэн байх;

СХ ХҮБ
Түшмэл
А/239

				• Үйл ажиллагааны хүрээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн 8-аас доошгүй бүтээлтэй байх.
2	Кадастр (газрын үнэлгээ, газар зүйн мэдээллийн систем)	Мэргэшсэн	Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж, дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх
			Ажилласан жил	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх
			Бусад шаардлага	• Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийн 7.11, 7.12 дугаар заалтын шаардлагыг хангасан байх; • Мэргэшлийн зэрэг сунгах мэргэжилтэн нь мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулахад оролцсон, хянан тохиолдуулсан, шүүмж хийсэн, санал өгч тусгуулсан байх; • Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах программ хангамжийг бүрэн эзэмшсэн байх; • Үйл ажиллагааны хүрээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн 5-аас доошгүй бүтээлтэй байх.
		Зөвлөх	Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж, дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх
			Ажилласан жил	Мэргэжлээрээ 11-ээс доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх
			Бусад шаардлага	• Тухайн мэргэжлийн хүрээнд мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх; • Мэргэжлийн чиглэлээр 2-оос доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулахад оролцсон, хянан тохиолдуулсан, шүүмж хийсэн, санал өгч тусгуулсан байх; • Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийн 7.13, 7.14 дүгээр заалтын шаардлагыг хангасан байх; • Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах программ хангамжийг бүрэн эзэмшсэн байх. • Үйл ажиллагааны хүрээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн 8-аас доошгүй бүтээлтэй байх.
3	Геодезийн хэмжилт, зураглал (сансрын геодези,	Мэргэшсэн	Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж, дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх
			Ажилласан жил	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх

ХХ УУБ
тушаал
А/239

	астрономи, инженер геодези, геодезийн мэдээлэл зүй, хэрэглээний геодези, агаарын зураглал, аэрофотогеодези)		Бусад шаардлага	- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийн 7.11, 7.12 дугаар заалтын шаардлагыг хангасан байх; - Мэргэшлийн зэрэг сунгах мэргэжилтэн нь мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулахад оролцсон, хянан тохиолдуулсан, шүүмж хийсэн, санал өгч тусгуулсан байх; - Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах программ хангамжийг бүрэн эзэмшсэн байх; - Үйл ажиллагааны хүрээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн 5-аас доошгүй бүтээлтэй байх.
			Зөвлөх	
			Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж, дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх
			Ажилласан жил	Мэргэжлээрээ 11-ээс доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх
4	Зураг зүйн	Мэргэшсэн	Бусад шаардлага	- Тухайн мэргэжлийн хүрээнд мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх; - Мэргэжлийн чиглэлээр 2-оос доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулахад оролцсон, хянан тохиолдуулсан, шүүмж хийсэн, санал өгч тусгуулсан байх; - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийн 7.13, 7.14 дүгээр заалтын шаардлагыг хангасан байх; - Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах программ хангамжийг бүрэн эзэмшсэн байх; - Үйл ажиллагааны хүрээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн 8-аас доошгүй бүтээлтэй байх.
			Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж, дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх
			Ажилласан жил	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх
			Бусад шаардлага	- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын ажилтныг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийн 7.11, 7.12 дугаар заалтын шаардлагыг хангасан байх; - Мэргэшлийн зэрэг сунгах мэргэжилтэн нь мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулахад

ЭХ ХҮБЬ

ДЭМЖЛЭЛЭЙН ХТ НЭГ

ДТЛЭЭ

А/239

тушаал

				оролцсон, хянан тохиолдуулсан, шүүмж хийсэн, санал өгч тусгуулсан байх; - Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах программ хангамжийг бүрэн эзэмшсэн байх; - Үйл ажиллагааны хүрээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн 5-аас доошгүй бүтээлтэй байх.
		Зөвлөх	Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль төгсөж, дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх
			Ажилласан жил	Мэргэжлээрээ 11-ээс доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх
			Бусад шаардлага	- Тухайн мэргэжлийн хүрээнд мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх; - Мэргэжлийн чиглэлээр 2-оос доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулахад оролцсон, хянан тохиолдуулсан, шүүмж хийсэн, санал өгч тусгуулсан байх; - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийн 7.13, 7.14 дүгээр заалтын шаардлагыг хангасан байх; - Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах программ хангамжийг бүрэн эзэмшсэн байх; - Үйл ажиллагааны хүрээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн 8-аас доошгүй бүтээлтэй байх.

__о О о__

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын
мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг
олгох, сунгах дүрмийн хоёрдугаар хавсралт



МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГЭРЧИЛГЭЭ


Дугаар:

танд

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын оны дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тушаалаар **МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР**-ийн зэргийг-ын
хүрээнд авсан тул гэрчилгээ, баталгааны тэмдэг олгов.
..... оны дугаар сарын-ны өдөр хүртэл хүчинтэй.

ДАРГА

Улаанбаатар хот
..... он



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГЭРЧИЛГЭЭ


Дугаар:

танд

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын оны дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тушаалаар **ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР**-ийн зэргийг-ын
хүрээнд авсан тул гэрчилгээ, баталгааны тэмдэг олгов.
..... оны дугаар сарын-ны өдөр хүртэл хүчинтэй.

ДАРГА

Улаанбаатар хот
..... он



Засгийн газрын хэрэгсэлтний газрын
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЭХ ХУВЬ

Улаанбаатар хот
2023-09-25

А/239



Засгийн газрын хэрэгсүүлэгч агентлаг
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАГ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮҮН БЭРЭГЖИЙ ГАЗАР

ЭХ ХУВЬ

ХАМГААГАХ ГАЗАР

Хуучин
1/239

МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ХУВИЙН ТЭМДЭГИЙН ЗАГВАР



__о О о__

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын
мэргэжилтнийг даван сургах, мэргэшлийн зэрэг
олгох, сунгах дүрмийн гуравдугаар хавсралт



.....-ийн.....-ний
(эцэг, эхийн нэр) (нэр)

БҮТЭЭЛИЙН ТАЙЛАН

№	Бүтээлийн нэр	Гүйцэтгэсэн хугацаа, он, сар	Өөрөө гүйцэтгэсэн, оролцсон, хэрэгжүүлсэн аль нь болох	Шийдвэр гаргасан, баталгаажуулсан байгууллага, албан тушаалтан
1				
2				
3				

Тайлан бичсэн мэргэжилтэн:..... (.....)
(гарын үсэг) (нэр)

Хянаж баталгаажуулсан: (.....)
(гарын үсэг) (нэр)
(тэмдэг)

__о О о__

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын
мэргэжилтнийг даван сургах, мэргэшлийн зэрэг
олгох, сунгах дүрмийн гуравдугаар хавсралт
ЭХ ХҮБ
тушаал
А/239

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын
мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг
олгох, сунгах дүрмийн дөрөвдүгээр хавсралт



.....-ийн-ний
(эцэг, эхийн нэр) (нэр)


МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН ТАЙЛАН

Танхимын хэлбэрээр багц цаг хангасан байдал						
№	Сургалтын нэр, ерөнхий агуулга, сэдэв	Хугацаа он, сар, өдөр	Хамтарч оролцсон байдал	Бодит цагийн хэмжээ	Багц цаг болон багц цагт шилжүүлсэн байдал	Сургалт зохион байгуулсан байгууллагын нэр
1						
2						
3						
Танхимын бус хэлбэрээр багц цаг хангасан байдал						
№	Оролцож хэрэгжүүлсэн арга хэмжээний хэлбэр	Хугацаа	Оролцсон үүрэг	Бодит ажилласан цаг	Багц цаг	Холбогдох байгууллага, аж ахуйн нэгж
1						
2						
3						

Тайлан бичсэн мэргэжилтэн:..... (.....)
(гарын үсэг) (нэр)

Хянаж баталгаажуулсан: (.....)
(гарын үсэг) (нэр)
(тэмдэг)

__ооо__



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын
мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг
олгох, сунгах дүрмийн тавдугаар хавсралт

**МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОХ МЭРГЭЖИЛТНИЙ
ӨРГӨДЛИЙН МАЯГТ**



Нэг. Анкетын хэсэг

1. Эцэг (эх)-ийн нэр	Нэр	Нас.....	Хүйс	3x4 хэмжээний зураг
2. Регистрийн дугаар				
3. Шуудангийн хаяг(e-mail хаяг).....				
4. Гэрийн хаяг.....				
.....				
5. Ажлын хаяг				
6. Утас: Ажлын.....Гэрийн.....Гар утас.....				

Хоёр. Ажил эрхлэлт

№	Албан газар	Албан тушаал	Орсон	Гарсан	Ажлаас өөрчлөгдсөн шалтгаан
			Огноо		
1					
2					
3					
4					
5					

Гурав. Боловсролын байдал

№	Хаана, ямар сургууль	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил	Гэрчлэх баримтын	
		Огноо			Нэр	Дугаар
1						
2						
3						
4						
Мэргэшүүлэх сургалтууд						
1	Хаана, ямар сургалтад хамрагдсан		Он, сар. Үргэлжилсэн хугацаа, хоногоор			

МЭРГЭЖИЛТНИЙ ЗЭРЭГ
ЭХ ХҮБ
А/239

2				
3				
4				

Дөрөв. Бүтээлийн жагсаалт

№	Бүтээлийн нэр	Бүтээлийн товч агуулга, үр дүн, ач холбогдол
А. Судалгааны ажил		
1		
2		
Б. Үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн шинэ арга, техник, технологи		
1		
2		
3		
В. Хэвлүүлсэн материалууд		
1		
2		
3		

Одоо.....хүрээнд.....
зэрэг **горилох** хүсэлт гаргаж байна.

Үнэн зөв болохыг баталсан:

Өргөдөл гаргагч: ()

(гарын үсэг)

(нэр)

__о О о__

МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОХ, СУНГАХ МЭРГЭЖИЛТНИЙ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Нэг. Анкетын хэсэг

1.Эцэг (эх)-ийн нэр	Нэр	Нас.....	Хүйс
2.Регистрийн дугаар			
3.Шуудангийн хаяг(е-mail хаяг).....			
4.Гэрийн хаяг.....			
5.Ажлын хаяг			
6.Утас: Ажлын.....Гэрийн.....Гар утас.....			

3x4

хэмжээний

зураг

Хоёр. Ажил эрхлэлт

№	Албан газар	Албан тушаал	Орсон	Гарсан	Ажлаас өөрчлөгдсөн шалтгаан
			Огноо		
1					
2					
3					
4					

Гурав. Боловсролын байдал

№	Хаана, ямар сургууль	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил	Гэрчлэх баримтын	
		Огноо			Нэр	Дугаар
1						
2						
3						
4						

Мэргэшүүлэх сургалтууд						
1	Хаана, ямар сургалтад хамрагдсан		Он, сар. Үргэлжилсэн хугацаа, хоногоор			
2						
3						

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Регистрийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ГЕОДЕЗИ, ЗУРАГ, ТУХИЙ ГЭРЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

3x ХУВЬ

Тушаал

А/239

4				
---	--	--	--	--

Дөрөв. Бүтээлийн жагсаалт

№	Бүтээлийн нэр	Бүтээлийн товч агуулга, үр дүн, ач холбогдол
А. Судалгааны ажил		
1		
2		
Б. Үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн шинэ арга, техник, технологи		
1		
2		
3		
В. Хэвлүүлсэн материалууд		
1		
2		
3		

Урьд ньондзэрэг горилох шалгалтанд орж
.....хүрээнд.....зэрэг хамгаалсан.

Гэрчилгээний дугаарОлгосон (сунгасан)
.....он.....сар.....өдөр

Одоо.....хүрээнд..... зэрэг
сунгах хүсэлт гаргаж байна.

Үнэн зөв болохыг баталсан:

Өргөдөл гаргагч: (.....)
(гарын үсэг) (нэр)

__о О о__

